



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2019/6



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	
Аргачлалын тайлбар.....	
I. Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III. Эрүүл мэнд	
IV. Гэмт хэрэг	
V. Үнэ.....	
VI. Төсөв.....	
VII. Хөдөө аж ахуй	
VIII. Аж үйлдвэр	
IX. Цаг уур.....	
Хавсралт.....	



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо

+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй

* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт



мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ 1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ 1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны эхний 2 сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.



- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал




I. Нийгмийн байдал

I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 292, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 191 байгаагийн 97 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 69 хүн буюу 26.5 хувиар, өмнөх сараас 10 хүн буюу 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зургаадугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 53 ажлын байрны захиалга ирж 33 иргэн ажилд зуучлагдсаны 12 буюу 36.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст




Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 50, 25-34 насны 68, 35-44 насны 45, 45-54 насны 26, 55 түүнээс дээш насны 2 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 6 сарын байдлаар 203 эх амаржиж, 206 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 35 буюу 14.7 хувиар, төрсөн хүүхдийн тоо 33 буюу 13.8 хувиар тус тус буурсан байна. Нас баралт 40, бүртгүүлсэн гэр бүл 32, цуцалсан гэр бүл 14 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 1 буюу 7.7 хувиар, нас баралт 4 буюу 11.1 хувиар тус тус нэмэгдэж, бүртгүүлсэн гэр бүл 18 буюу 36.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 2 хүүхэд үрчлэгдэж, 169 хүн шилжин ирсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 37.2 хувиар буурсан байна.

Зураг I.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар





II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2019 оны эхний 6 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 5946.8 сая төгрөг, зарлага 5867.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 815.8 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар, зарлага 616.9 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 153.7 хувьтай, зарлагын гүйцэтгэл 99.1 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2019 оны эхний 6 сарын байдлаар 5625 хүнд 1108.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 167 хүн буюу 3.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 75.9 сая төгрөг буюу 7.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 1764 хүн хамруулж 614.5 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 71 хүн буюу 3.9 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 35.3 сая төгрөг буюу 6.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 3861 хүн хамруулж 494.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 238 хүн буюу 6.6 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 40.1 сая төгрөг буюу 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

II.3 Дундаж цалин

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 6 дугаар сарын мэдээгээр 205 байгууллагын 5006 даатгуулагч иргэн, үүнээс 355 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 315 ажилтны дундаж цалин 1092.0 мянган төгрөг, төсөвт 54 байгууллагын 1649 ажилтны дундаж цалин 918.9 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 613 ажилтны дундаж цалин 1621.0 мянган төгрөг, 115 ХХКомпаний 1940 ажилтны дундаж цалин 1029.0 мянган төгрөг, бусад 23 аж ахуйн нэгж байгууллагын 134 ажилтны дундаж цалин 660.6 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2019 оны 6 сарын байдлаар






III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2019 оны эхний 6 сарын байдлаар 209 эх амаржиж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 35 буюу 14.3 хувиар буурсан байна.


Амьд төрсөн хүүхэд 210 үүнээс 113 нь хүү, 97 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 34 буюу 13.9 хувиар буурсан байна. Он гарсаар 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 гарч, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй болно.

Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Халдварт өвчин эхний 6 сарын байдлаар 104 буюу 10000 хүн амд 63.0 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.9 промилоор буурчээ.

Зураг III.2. Нас баралт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 48976 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 6768 буюу 12.1 хувиар, 2514 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 89 буюу 3.4 хувиар буурсан байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3108, халдварт өвчин 104 бүртгэгдсэн байна.

Зураг III.3. Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 6 сарын байдлаар





IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 6 сарын байдлаар 88 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 буюу 21.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Илрээгүй гэмт хэрэг 45 байгаа нь өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар буурсан. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 44.4 болсон нь өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 45 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2019 оны эхний 6 сарын байдлаар 133.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 53.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 282.0 сая төгрөгөөр буюу 3.1 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 160.0 сая төгрөг буюу 3.6 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна. Давхардсан тоогоор 384 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15 хүнээр буюу 4.1 хувиар өссөн байна.

Зураг IV.3.Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 6 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс тайлант сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, 2018 оны жилийн эцсээс 4.8 хувиар өсч, өмнөх сараас 0.6 хувиар буурсан байна.

Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 6 дугаар сард, бүлгийн дүнгээр


Бараа үйлчилгээний бүлэг	2019. VI	2019. VI	2019. VI
	2018. VI	2018. XII	2019. V
Ерөнхий индекс	106.9	104.8	99.4
Хүнсний бараа, ундаа, ус	116.0	116.9	97.6
Согтууруулах ундаа, тамхи	108.7	103.4	100.3
Хувцас, бөс бараа, гутал	102.4	101.9	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.0	100.7	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	107.4	103.9	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	99.2	100.7	100.0
Тээвэр	102.9	97.9	99.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.4	99.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	114.2	100.2	100.2
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	104.6	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	110.5	104.6	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ



VI. Төсөв санхүү, банк

2019 оны эхний 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 7965.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 8152.1 сая төгрөг болж 102.3 хувийн биелэлттэй байна. Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 9741.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 8101.6 сая төгрөг болж 83.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Авлагын үлдэгдэл 42.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 301.2 сая төгрөг байна. Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр




Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын мэдээллийг эхний хагас жилийн байдлаар танилцуулбал цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид давхардсан тоогоор 19.9 мянгад хүрч, зээлийн бүтээгдэхүүн 24 болсон байна. Давхардсан тоогоор 43 аж ахуйн нэгж байгууллагад 1.7 тэрбум төгрөгийн, 8976 иргэнд 54.1 тэрбум төгрөгийн, үүнээс 498 малчинд 2.2 тэрбум төгрөгийн зээл олгосон үзүүлэлттэй байна.


**VII. Мал аж ахуй, газар тариалан**

Аймгийн хэмжээнд оны эхний нийт 203579 хээлтэгч малын 156575 буюу 76.9 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 98.4 хувьтай байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар 2804 толгой том мал зүй бусаар хорогдсон эны эхний малын 0.7 хувийг эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 22.6 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор



Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор



2019 оны 6 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 47.8 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 2.7 га талбайгаар буюу 18.0 хувиар, хүнсний ногоо 5.82 га талбайгаар буюу 44.8 хувиар өсч, тэжээлийн ургамал 1.0 га талбайгаар буюу 8.3 хувиар буурсан байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, га



**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны эхний 6 сарын байдлаар 24.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.7 тэрбум төгрөг буюу 0.3 хувиар, оны үнээр 27.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 тэрбум төгрөг буюу 11.6 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 90.3 хувь буюу 22.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.9 хувь буюу 25.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

**IX. Цаг агаарын мэдээ 6 дугаар сарын байдлаар**

Хур тундас: 01, 04, 09, 11, 15, 16, 17, 23, 25, 27, 28-ны өдрүүдэд бороо орж, нийт 20.5 мм тунадас орсон. Салхи: Энэ сард ихэнхи хугацаанд салхи 6-11 м/сек, зарим үед 12-17 м/сек хүрч ширүүссэн. Агаарын температур: Агаарын температур нэгдүгээр арав хоногт 5-10 градус, бусад хугацаанд 13-18 градус, өдөртөө 25-30 градус, 1 ба 2 дугаар арав хоногийн эхээр 23-28 градус, бусад хугацаанд 26-31 градус дулаан байна.

ДОЛООДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь 18-26 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлийн хагас, гуравдугаар арав хоногийн эхээр бага зэрэг сэрүүсч шөнөдөө 9-14 градус, өдөртөө 19-24 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 16-21 градус, өдөртөө 28-33 градус дулаан байх ба нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр өдөртөө 31-36 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард олон жилийн дундаж орчим бороо орох төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр бага зэргийн бороо, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, сүүлчээр түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур ширүүснэ.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	244	210	86.1
Ажил хайгч ажилгүй иргэд, тайлант сарын эцэст	хүн	260	191	73.5
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	139	104	74.8
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	112	88	78.6
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	7440.3	8152.1	109.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	7334.8	8101.6	110.5
Авлага	сая.төг	43.5	42.0	96.6
Өглөг	сая.төг	150.7	301.2	199.9
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	24025.5	24745.4	103.0
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	24477.3	27326.0	111.6
Төллөсөн хээлтэгч	толгой	141521	156575	110.6
Гарсан төл	толгой	142481	157130	110.3
Хорогдсон төл	толгой	21560	2562	11.9
Бойжсон төл	толгой	120921	154568	127.8
Том малын зүй бусын хорогдол	толгой	30591	2804	9.2



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 VI	2019 VI	$\frac{2019 VI}{2018 VI} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	437	292	66.8
Үүнээс: эмэгтэй	249	149	59.8
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	260	191	73.5
Үүнээс: эмэгтэй	141	97	68.8
Ажлын байрны захиалга	84	53	63.1
Ажилд зуучлагдсан иргэд	36	33	91.7
Үүнээс: эмэгтэй	15	12	80.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Үрчлэгдсэн хүүхэд	4	2	50.0
Бүртгүүлсэн гэр бүл	50	32	64.0
Цуцалсан гэр бүл	13	14	107.7
Нас баралт	36	40	111.1
Шилжин ирсэн	269	169	62.8

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сангийн төрөл	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	5 131.1	5 946.8	115.9
НД-ын сангийн зарлага, сая.төг	5 250.2	5 867.1	111.8

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ

II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI		2019 I-VI		$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	5 458	1 033.0	5 625	1 108.9	103.1	107.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 835	578.8	1 764	614.5	96.1	106.2
Халамжийн тэтгэвэр	250	201.1	242	235.9	96.8	117.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 585	377.7	1 522	378.5	96.0	100.2
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны хишиг	1 312	144.8	1 452	149.9	110.7	103.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт,	71	14.1	125	15.7	176.1	111.3



тусламж

Нийгмийн халамжийн үйлчилгээ	694	47.7	710	52.6	102.3	110.3
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	294	84.9	291	101.1	99.0	119.1
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	5.1	6	6.0	120.0	117.6
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 247	166.4	1 277	169.1	102.4	101.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Төрсөн эх	244	209	85.7
Амьд төрсөн хүүхэд	244	210	86.1
Эрэгтэй	120	113	94.2
Эмэгтэй	124	97	78.2
Амьгүй төрсөн хүүхэд	0	2	-
Нийт нас баралт	27	26	96.3
Эмнэлгийн нас баралт	5	7	140.0
Хоног болоогүй нас баралт	1	3	300.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	4	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0	-
Эмчлэгдсэн өвчтөн	2 603	2 514	96.6
Амбулаторийн үзлэг	55 744	48 976	87.9
Халдварт өвчин	139	104	74.8

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	112	88	78.6
Хүний амьд явах эрхийн эсрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	58	36	62.1
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	34	35	102.9
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	6	9	150.0
Гэмт хэрэгт холбогдогсод	56	48	85.7
15 хүртэлх насны	0	0	-
16-34 насны	35	26	74.3
35 ба түүнээс дээш насны	21	22	104.8
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	14	14	100.0
Ажилгүй иргэд үйлдсэн	31	20	64.5
Эмэгтэй хүн оролцсон	13	5	38.5
Хүүхэд оролцсон	4	0	-
Бүлгээр үйлдсэн	6	4	66.7
Согтуугаар үйлдсэн	32	23	71.9



Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	112	88	78.6
Гудамж талбай, олон нийтийн газар	30	22	73.3
Гэмт хэргийн улмаас нас барсан	2	5	250.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	56	45	80.4
Учирсан хохирол / сая.төг /	415.0	133.0	32.0
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	190.0	53.0	27.9

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нийт орлого	7 440.3	8 152.1	109.6
Урсгал орлого	2 480.2	2 696.7	82.4
Татварын орлого	2 237.6	2 378.2	100.0
Татварын бус орлого	242.6	318.5	31.4
Тусламжийн орлого	4 960.1	5 455.4	108.4

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нийт зарлага	7 334.8	8 101.6	110.5
Урсгал зардал	6 648.6	7 460.5	112.2
Хөрөнгийн зардал	486.2	641.2	131.9

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Авлага	43.5	42.0	96.6
Өглөг	150.7	301.2	199.9
Төсөвт байгууллагын тоо	49	48	98.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Бүгд	141 521	156 575	110.6
Ингэ	139	126	90.6
Гүү	2 715	3 304	121.7
Үнээ	3 309	3 334	100.8
Эм хонь	71 775	81 942	114.2
Эм ямаа	63 583	67 869	106.7



VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Дүн	141 521	141 521	110.6
<u>Баянтал</u>	26 248	26 071	99.3
<u>Сүмбэр</u>	98 483	100 393	101.9
<u>Шивээговь</u>	16 790	20 110	119.8

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Бүгд	120 921	154 568	127.8
Ботго	133	116	87.2
Унага	2 513	3 226	128.4
Тугал	3 100	3 292	106.2
Хурга	63 702	80 990	127.1
Ишиг	51 473	66 944	130.1

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Дүн	120 921	154 568	127.8
<u>Баянтал</u>	25 411	25 932	102.1
<u>Сүмбэр</u>	78 720	108 544	137.9
<u>Шивээговь</u>	16 790	20 092	119.7

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Бүгд	30 591	2 804	9.2
Тэмээ	7	9	128.6
Адуу	1 147	78	6.8
Үхэр	1 607	68	4.2
Хонь	11 269	1 094	9.7
Ямаа	16 561	1 558	9.4

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Дүн	30 591	2 804	9.2
<u>Баянтал</u>	2 217	370	16.7
<u>Сүмбэр</u>	27 897	2 331	8.4
<u>Шивээговь</u>	477	103	21.6



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Бүгд	6 357	635	10.0
Тэмээ	1	3	300.0
Адуу	288	21	7.3
Үхэр	332	16	4.8
Хонь	2 126	291	13.7
Ямаа	3 610	304	8.4

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Дүн	6 357	635	10.0
<u>Баянтал</u>	354	16	4.5
<u>Сүмбэр</u>	5 878	599	10.2
<u>Шивээговь</u>	125	20	16.0

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нийт	21 025.5	24 745.4	103.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	22 694.7	22 250.5	98.0
Боловсруулах аж үйлдвэр	60.8	188.3	309.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 270.0	2 306.6	181.6

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нийт	24 477.3	27 326.0	111.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	23 155.0	25 880.0	111.8
Боловсруулах аж үйлдвэр	51.5	44.9	87.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 270.8	1 401.0	110.2

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	$\frac{2019 I - VI}{2018 I - VI} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	23 155.0	25 880.0	111.8
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	22 694.7	22 250.5	98.0
Ажиллагсад	537	564	105.0



Е-мэйл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017